

## **МАСАРУ ТАНАКАГА: ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС ӨНДӨР БАЙВАЛ БОДЛОГЫН ХҮҮГ ӨСГӨХ НЬ ЗӨВ**

**Японы Төвбанкны Азийн мөнгөний бодлогын харилцах албаны төвийн дарга Масару Танакагаас дараах зүйлийг тодрууллаа.**

**-Японд инфляцийг нэн тэргүүнд тавьдаг уу, эсвэл эдийн засгийн өсөлтийг чухалчилж үздэг үү?**

-Инфляцийг тодорхой хэмжээний төвшинд хүргэж барих биш аль болох багасгах бодлогыг илүү их баримталдаг. Инфляц бага байснаар эдийн засгийнхаа өсөлтийг дэмжинэ. Яагаад гэвэл, үнэ тогтвортой байдаг.

**-Манай улсад инфляцийг хязгаарлахын тулд Төвбанк бодлогын хүүгээ нэмсэн. Бодлогын хүүг нэмснээр зээл хязгаарлагдах зэргээр сөрөг үр дагавартай. Энэ нь одоогоор мэдрэгдээгүй байгаа ч гарч болзошгүй гэдэг үүднээс зарим нь бодлогын хүүг бууруулаач, нөгөө нь эдийн засгийн өсөлтөө авч гарах нь хэрэгтэй гэж ярьдаг. УИХ-ын гишүүдийн ингэж ярих нь зөв үү, буруу юу?**

-Японы хувьд хэрэглээний үнийн индекс нь өссөн тохиолдолд бодлогын хүүгээ өсгөж, инфляцийг тогтворжуулах бодлого баримталдаг. Харин хэрэглээний үнийн индекс нь бага боловч байр, орон сууц гэхчилэнгээр үл хөдлөх хөрөнгийн үнэ өсөөд байвал тэр үед бодлогын хүүгээ өсгөхгүй, жаахан доогуур байлгах нь зүйтэй гэж үздэг. Монголын хувьд ч хэрэглээний үнийн индекс өндөр байвал бодлогын хүүгээ өсгөх нь зөв алхам.